



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 366

Улаанбаатар хот

┌ Сүхбаатар аймгийн орон нутгийн бондыг бүртгэх тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.2, 7.1 дэх заалт, Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2011 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Сүхбаатар аймгаас гаргах 12 сарын хугацаатай, жилийн 12 хувийн хүүтэй, нэг бүр нь 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,000 /таван мянга/ ширхэг, 18 сарын хугацаатай, жилийн 12.5 хувийн хүүтэй, нэг бүр нь 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 15,000 /арван таван мянга/ ширхэг нийт 2,000,000,000 /хоёр тэрбум/ төгрөгийн үнийн дүн бүхий 20,000 /хорин мянга/ ширхэг орон нутгийн бондыг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар/Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтанд бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, төвлөрсөн хадгаламжинд бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК/Д.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Бонд гаргах тухай үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаасны газраар баталгаажуулан, уг үнэт цаасны танилцуулгад үндэслэн олон нийтэд үнэ төлбөргүйгээр нийтлэг мэдээлэл хүргэхийг Сүхбаатар аймгийн Засаг дарга/Ж.Батсуурь/, “Би Ди Сек” ХК/Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

3. Дараах нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд бондыг хөрөнгийн биржийн арилжаанд оруулахыг Хорооны даргад зөвшөөрсүгэй:

1/ Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 2012 онд төлөгдөх бондын үндсэн болон хүүгийн төлбөрт шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг батлуулан орон нутгийн төсөвт суулгаж, холбогдох шийдвэрийг Хороонд ирүүлэх;

2/ Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд заасны дагуу тус аймгаас улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлэх шаардлагатай 870,3 /найман зуун далан сая гурван зуун мянга/ сая төгрөгийг бүрэн төвлөрүүлэн холбогдох баримтыг Хороонд ирүүлэх;

3/ Тус аймгийн улсын төсвийн эзэлийн үлдэгдэл болох 635,0 /зургаан зуун гучин тав/ сая төгрөгийг бүрэн төлж барагдуулан холбогдох баримтыг Хороонд ирүүлэх.

4. Энэхүү журмын 3 дахь хэсэгт заасан Хорооны даргын зөвшөөрөл гарах хүртэлх хугацаанд бондыг хөрөнгийн биржийн арилжаанд оруулахгүй байхыг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/-д үүрэг болгосугай.

5. Арилжааны тайланг хуульд тогтоосон хугацаанд Хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллахыг Сүхбаатар аймгийн Засаг дарга/Ж.Батсуурь/, “Би Ди Сек” ХК/Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

6. Бондын борлуулалт, үндсэн болон хүүгийн эргэн төлөлтөд холбогдох журмын дагуу хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, “ҮЦТТТХТ” ХХК/Д.Гандулам/-д даалгасугай.

7. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН